



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 10 дугаар сарын 20 өдөр Дугаар 88 Хэрлэн сум

LXXXVIII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 88 дугаар хуралдаан 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 09:00 цагт танхимаар 80,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдлын мэдээллийг танилцуулах,

Аймгийн ерөнхий тархвар судлаач

2.Малын өвчний нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,

Мал эмнэлгийн газар

3.Аймгийн Онцгой комиссын 2021 оны “Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай” 110 дугаар тогтоолыг сунгах эсэх талаар хэлэлцэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

4.”ДБЭХС” ТӨХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн албан бичиг танилцуулах,

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат

5.Улсын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн албан бичиг танилцуулах,

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат

6.Эрүүл мэндийн сайдын “Нэмэлт дархлаажуулалтыг эрчимжүүлэх тухай” албан бичиг танилцуулах,


Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

7.Улсын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан бичиг, зөвлөмжийг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

8.Бүсийн оношлогоо эмчилгээний төвөөс аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийг танилцуулах,

Аймгийн ерөнхий тархвар судлаач

 / М.Бадамсүрэн
/ х/а Г.Нармандах

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.1.Аймгийн Онцгой комиссын 2021 оны “Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай” 110 дугаар тогтоолын хэрэгжих хугацааг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгах талаар аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

1.2.Хөл хорио, хязгаарлалттай холбоотой аймгийн Онцгой комиссоос гаргасан шийдвэрүүдийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх,

1.3.Сургуулийн орчинд халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор “Гэр сургууль гэр” маршрутыг хэрэгжүүлж ажиллах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар аймгийн Онцгой комисст ирүүлэх талаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт чиглэл хүргүүлэх,

1.4.”ДБЭХС” ТӨХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Өргөтгөлийн бараа материалыг Баянхошуу хилийн боомтоор нэвтрүүлэх тухай” албан бичгийн дагуу хэлэлцэж зөвшөөрсөн талаар тухайн байгууллагад хариу хүргүүлэх,

Хоёр.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Э.Жавхлан,
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Базаррагчаа нарт:

2.1.Улсын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан бичиг, зөвлөмжийн дагуу Эрүүл мэндийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газруудын хамтарсан тушаал гаргаж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

Гурав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

3.1.Эрүүл мэндийн яамнаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн албан бичиг, төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах,

3.2.Сумдад томилолтоор ажиллах албан хаагч нарт халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэхэд хяналт тавьж ажиллах,

Дөрөв.АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д:

4.1.Бүсийн оношлогоо эмчилгээний төвөөс аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Сод дэн буудал түрээслэсэн зардлыг шийдвэрлүүлэх тухай” хүсэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг тус тус үүрэг болгов.

ДАРГА

М.БАДАМСҮРЭН

ОРЛОГЧ ДАРГА,
ХУРАНДАА

Г.НАРМАНДАХ

